

**Петро Матад Лимитед ("Петро Матад" эсвэл "Компани" гэх)  
Үйл Ажиллагааны Шинэчидсэн Мэдээлэл**

Петро Матад компани нь Монгол орны зүүн хэсэгт байрлах, Бүтээгдэхүүн Хуваах Гэрээт ("БХГ" гэх) Матад ХХ талбай дахь Давсан Толгой Төслийн үйл ажиллагааны шинэчилсэн мэдээллийг хүргэж байна.

Компани Давсан Толгой-8 цооногийн ("ДТ-8" гэх) туршилтын анхны үр дүнгийн үнэлгээг хийж дууслаа. Цооногоос байгалийн даралтаар ундарга байгаагүй бөгөөд Петро Матад компани тус цооногийг агуулагч давхаргад цаашдын үнэлгээг хийх боломжтой болгохын тулд хагалбарын ажил гүйцэтгэхээр төлөвлөж байна.

ДТ-8 цооногийн туршилтыг 2011 оны 09 дүгээр сарын 15-28 өдрүүдэд гүйцэтгэсэн. Дээд Цагаанцавын формацийн дээд хэсгийн 1,711-1,720 метрт байгаа судалгааны үндсэн хэсэг болон 1,773-1,779 метрт байгаа хоёр дахь хэсэгт туршилтыг тус тус гүйцэтгэсэн. Тос, усны анхан шатны шинжилгээний үр дүнг 2011 оны 10 дугаар сарын 14-нд хүлээж авсан.

1,711-1,720 метрт байгаа судалгааны үндсэн хэсгээс бага хэмжээний тос ба ус гаргаж авсан. Даралтын мэдээллээр өрөмдлөгийн шингэний нөлөөнд нэвчүүлэмж нь муудсан хэсгийн нэвчүүлэмжийн үзүүлэлт бага байгаа нь тогтоогдсон. Эдгээр үр дүнгүүдийг тухайн бүс нутгийн Цагаанцавын агуулагч давхаргын нэвчүүлэмж багатай, өрмийн шингэнд мэдрэмтгий хэсгийн анхны шингэний урсгалын мэдээлэлтэй харьцуулан судалж байна.

Судалгааны хэсгээс ялгарсан тос, петрофизикийн бичиглэл зэрэг нь цаашид энэ хэсэгт шингэн хагалбар гүйцэтгэх боломжтойг харуулж байна.

Судалгааны хоёр дахь хэсэг буюу 1,773-1,779 метрээс ямар нэгэн шингэн илрээгүй. Даралтын мэдээллээр энэхүү үе нь нэвчүүлэмж багатай, шингэн хагалбар хийх шаардлага хангахгүй гэж үзэж байна.

Петро Матад компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даг МакГэй хэлэхдээ "ДТ-8 цооногийн туршилт нь Цагаанцавын агуулагч давхаргуудын урсгалын шинж чанарын анхан шатны судалгааны үргэлжлэл юм. Дээд Цагаанцавын дээд хэсэг болон Доод Цагаанцавын агуулагч давхаргууд нь талбайн ойр орчмын олборлолтын талбайдтай ижил төстэй болох нь тогтоогдлоо. Эдгээр нарийн төвөгтэй агуулагч давхаргууд доторхи шингэнд мэдрэмжийн шавар болон галт уулын гаралтай цементийн нөлөөгөөр нэвчүүлэмж багассан учир хагалбарын ажил гүйцэтгэх шаардлагатай.

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүган хянасан болно. Доктор Күүган нь Хойд Америк, олон улсын хайгуул болон ашиглалтын чиглэлээр 29 жил ажилласан туршлагатай газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км<sup>2</sup> талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ ("БХГ" гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км<sup>2</sup> талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Мэний Аралд (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Даглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед  
Ерөнхий Гүйцэтгэх Захирал – Даглас Ж. МакГей (Douglas J. McGay)  
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитед  
Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)  
+44 (0)20 7601 6100